



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2025/131/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2025 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.27 № 204
танай 2025.01.28-ны № 5 -т

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ш.БАТЖАВ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд ажилтны цалинг 1,562.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан, 150,088.0 мянган төгрөгийн худалдан авалтад тендер зарлаагүй шууд худалдан авсан зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ, 10 дугаар зүйлийн 10.1-д Захиалагч тендер шалгаруулалтыг энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэгт заасан аргаар зохион байгуулна, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, 16.5.2-т Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт

011022093

тавих заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Тайлант жилд нийгмийн даатгалын систем шинэчлэгдэж, төрийн алба хаагчдын цалингийн нэгдсэн системд ажил мэргэжлийн код болон даатгуулагчийн кодыг зөрүүтэй оруулснаас ажилтнаас илүү дутуу шимтгэл суутгах, байгууллагаас төлөх шимтгэлийн хэмжээг илүү дутуу тооцоолсноос шалтгаалан жилийн эцэст авлага, өр төлбөр үүсэж тайланд залруулгууд хийгдсэн байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Дорнод аймгийн Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилго, 5 зорилт, 71 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	352,311,975.54	576,643,897.07
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	163,349,117.55	368,797,743.93
35	БАРАА МАТЕРИАЛ	188,962,857.99	207,846,153.14
351	Түүхий эд материал	4,695,700.00	4,695,700.00
354	Хангамжийн материал	184,267,157.99	203,185,453.14
35410	Бичиг хэргийн материал	52,707,035.86	73,202,917.10
35420	Аж ахуйн материал	122,546,666.13	110,502,076.04
35430	Сэлбэг хэрэгсэл		1,390,000.00
35460	Хүнсний материал	8,288,956.00	501,180.00
35470	Бусад хангамжийн материал	8,288,956.00	501,180.00
35600	Мал амьтад	724,500.00	17,589,280.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,001,479,674.97	6,456,047,913.95
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,001,479,674.97	6,456,047,913.95
392	Биет хөрөнгө	1,946,143,404.09	6,400,711,643.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,976,047,354.77	6,553,917,354.77
39202	Хуримтлагдсан элэгдэл	(537,640,964.65)	(701,393,397.73)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	75,000,000.00	75,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(75,000,000.00)	(75,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	521,812,867.50	556,143,534.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(236,543,243.05)	(250,885,383.79)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	118,786,038.98	166,036,556.12
39208	Хуримтлагдсан элэгдэл	(42,918,722.38)	(51,262,792.46)
39209	Зам, гүүрийн байгууламж	18,014,115.16	18,014,115.16
39210	Хуримтлагдсан элэгдэл - Зам гүүр	(3,542,799.48)	(6,610,255.80)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	60,351,150.00	60,351,150.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	112,710,349.90	112,809,349.90
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	(64,494,647.97)	(78,434,230.41)
39217	Номын фонд	23,561,905.31	22,025,643.31
39300	Биет бус хөрөнгө	55,336,270.88	55,336,270.88
39303	Бусад биет бус хөрөнгө	55,336,270.88	55,336,270.88
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,353,791,650.51	7,032,691,811.02
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,353,791,650.51	7,032,691,811.03
51	Засгийн газрын хувь оролцоо	2,353,791,650.51	7,032,691,811.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	434,020,522.80	434,020,522.80
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	1,291,878,627.90	5,970,778,788.42
51210	Өмнөх үеийн үр дүн	1,212,875,961.02	1,291,878,627.90
51220	Тайлант үеийн үр дүн	79,002,666.88	4,678,900,160.51
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	627,892,499.81	627,892,499.81
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,353,791,650.51	7,032,691,811.02

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,607,233,553.90	6,782,186,805
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	238,319,453.90	4,718,050,805
120	Нийтлэг татварын бус орлого	238,319,453.90	4,718,050,805
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,038,000	7,532,800
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,038,000	7,232,800

**Дорнод аймгийн Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

1200042	Туслах үйл ажиллагааны орлого		300,000
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	183,330,415	4,705,720,606.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	44,951,038.90	4,797,398.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,368,914,100	2,064,136,000
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,306,408,200	1,992,948,000
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,505,900	71,188,000
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,528,230,887.02	2,101,963,742.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,528,230,887.02	2,101,963,742.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,459,694,545.86	2,101,959,892.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	914,010,236.85	1,344,923,253.97
210101	Үндсэн цалин	652,765,851.08	879,312,888.19
210102	Нэмэгдэл	223,474,579.10	416,977,973.11
210104	Урамшуулал	37,769,806.67	46,541,823.51
210104	Гэрээт ажлын цалин		2,090,569.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,663,756.23	169,133,187.82
210201	Тэтгэврийн даатгал	79,040,659.48	108,843,928.36
210202	Тэтгэмжийн даатгал	9,204,730.66	23,822,021.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,359,544.51	7,006,795.21
210204	Ажилгүйдлийн даатгал	1,732,556.50	6,010,984.81
210205	Эрүүл мэндийн даатгал	17,326,265.08	23,449,458.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,500,358.84	65,748,000
210301	Гэрэл, цахилгаан	25,066,714.84	29,017,164.86
210302	Түлш, халаалт	32,433,644.00	35,930,835.14
210303	Цэвэр, бохир ус		800,000
2104	Хангамж, бараа материалын зардал		33,610,281.45
210401	Бичиг хэрэг		12,586,350
210402	Тээвэр, шатахуун		3,042,224
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		5,896,600
210408	Бараа материал акалсны зардал		12,085,107.45
2105	Нормативт зардал		159,124,028
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		299,600
210502	Хоол, хүнс	80,105,200	158,824,428
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,396,700	5,436,150
210604	Урсгал засвар	4,396,700	5,436,150
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,763,800	35,900,471.16
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	7,505,800	28,667,671.16
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	279,254,493.94	288,084,520.41
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	279,254,493.94	288,084,520.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,281,559.02	35,695,804.67
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,945,890	2,559,250
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	229,027,044.92	249,829,465.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,536,341.16	3,850.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,927,500	-
213205		56,757,000	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,170,500	-
2134	Орон нутгийн төвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас санхүүжилт		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	608,841.16	
213205	Төвлөрүүлэх шилжүүлэг		3,850.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	79,002,666.88	4,680,223,062.19
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		1,322,901.68
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	79,002,666.88	4,678,900,160.51

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,378,952,100</u>	<u>2,071,668,800</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>10,038,000</u>	<u>7,532,800</u>
120	Нийтлэг татварын бус орлого	-	300,000
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	300,000
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	-	300,000
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>1,368,914,100</u>	<u>2,064,136,000</u>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,306,408,200	1,992,948,000
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,505,900	71,188,000
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	62,505,900	71,188,000
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,348,408,218.10</u>	<u>1,866,220,173.62</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>1,348,408,218.10</u>	<u>1,866,220,173.62</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,277,199,331.94	1,803,699,911.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	914,010,236.85	1,344,923,253.97
210101	Үндсэн цалин	652,765,851.08	877,395,543.99
210102	Нэмэгдэл	223,474,579.10	417,657,938.30
210103	Урамшуулал	37,769,806.67	47,779,202.52
210105	Гэрээт ажлын цалин		2,090,569.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,663,756.23	169,133,187.82
210201	Тэтгэврийн даатгал	79,040,659.48	116,748,878.62
210202	Тэтгэмжийн даатгал	9,204,730.66	13,383,984.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,359,544.51	7,468,470.58
210204	Ажилгүйдлийн даатгал	1,732,556.50	6,425,267.66
210205	Эрүүл мэндийн даатгал	17,326,265.08	25,106,586.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,500,358.84	65,748,000.00
210301	Гэрэл, цахилгаан	25,066,714.84	29,017,164.86
210302	Түлш, халаалт	32,433,644.00	35,930,835.14
210303	Цэвэр, бохир ус		800,000.00
210502	Хоол хүнс	85,220,431	88,000,240
210604	Урсгал засвар	4,396,700	5,436,150
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,763,800.00	42,472,471.16
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,258,000	7,232,800
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	7,505,800	35,239,671.16
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	91,644,049.02	87,986,608.67
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	78,754,559.02	72,993,608.67
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,889,490.00	14,993,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71,208,886.16	<u>62,520,262.00</u>
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,600,045	<u>62,516,412</u>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,170,500	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	59,429,545	62,516,412
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	608,841.16	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	608,841.16	-
213503			3,850.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>30,543,881.90</u>	<u>205,448,626.38</u>

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	30,543,881.90	205,448,626.38
.9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	132,805,235.65	163,349,117.55
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	163,349,117.55	368,797,743.93

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	434,020,522.80	627,892,499.81	1,291,878,627.90	2,353,791,650.51
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	--	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	434,020,522.80	627,892,499.81	1,291,878,627.90	2,353,791,650.51
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	--	-	4,678,900,160.51	4,678,900,160.51
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	434,020,522.80	627,892,499.81	5,970,778,788.42	7,032,691,811.03

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл		163,349,117.55	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,233,924,700.00	1,866,220,173.62	367,704,526.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,233,924,700.00	1,866,220,173.62	367,704,526.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,233,924,700.00	1,866,216,323.62	361,815,488.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,649,823,600.00	1,344,923,253.97	304,900,346.03
210101	Үндсэн цалин	1,077,073,400.00	877,395,543.99	199,677,856.01
210102	Нэмэгдэл	549,246,300.00	417,657,938.30	131,588,361.70
210104	Урамшуулал	23,503,900.00	47,779,202.52	(24,275,302.52)
210105	Гэрээт ажлын хөлс		2,090,569.16	(2,090,569.16)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	206,228,000.00	169,133,187.82	37,094,812.18
210201	Тэтгэврийн даатгал	140,235,100.00	116,748,878.62	23,486,221.38
210202	Тэтгэмжийн даатгал	16,498,200.00	13,383,984.08	3,114,215.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,249,100.00	7,468,470.58	780,629.42
210204	Ажилгүйдлийн даатгал	8,249,100.00	6,425,267.66	1,823,832.34
210205	Эрүүл мэндийн даатгал	32,996,500.00	25,106,586.88	7,889,913.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,748,000.00	65,748,000.00	

Дорнод аймгийн Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	23,681,600	29,017,164.86	(5,335,564.86)
210302	Түлш, халаалт	39,442,400	35,930,835.14	3,511,564.86
210303	Цэвэр, бохир ус	2,624,000	800,000	1,824,000
210502	Хоол хүнс	103,127,600	88,000,240	15,127,360.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,440,000	5,436,150.00	3,850.00
210604	Урсгал засвар	5,440,000	5,436,150.00	3,850.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,476,900.00	42,472,471.16	4,428.84
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,233,300	7,232,800	500
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	35,243,600	35,239,671.16	3,928.84
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,671,300.00	87,986,608.67	4,684,691.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	77,675,200.00	72,993,608.67	4,681,591.33
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,996,100	14,993,000	3,100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,409,300	62,516,412	5,892,888
2132	Бусад урсгал шилжүүлэг	68,409,300	62,516,412	5,892,888
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	68,409,300	62,516,412	5,892,888
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР			
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ			
131001	Улсын төсвөөс санхүүжих			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		368,797,743.93	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО			
620001	Удирдах ажилтан			
620002	Гүйцэтгэх ажилтан			
620003	Үйлчлэх ажилтан			

2.5 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
80112	Нийтлэг үйлчилгээ	71,188,000.00	71,184,150.00	3,850.00
12	Татварын бус орлого	71,188,000.00	71,184,150.00	3,850.00
12200	Тусламжийн орлого	71,188,000.00	71,184,150.00	3,850.00
122005	Төсвөөс санхүүжих	71,188,000.00	71,184,150.00	3,850.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	71,188,000.00	71,184,150.00	3,850.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ			-
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ			-

2103	БАЙР АШИГЛАЛТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ	71,188,000.00	71,184,150.00	3,850.00
210301	Гэрэл, цахилгаан	29,705,600.00	29,017,164.86	688,435.14
21302	Түлш халаалт	35,242,000.00	35,930,835.14	(688,835.14)
21303	Цэвэр, бохир ус	800,000.00	800,000.00	-
210604	урсгал засвар	5,440,000.00	5,436,150.00	3,850.00
26	Төвлөрүүлэх шилжүүлэг			
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг			3,850.00

2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 27.5 сая төгрөгийн 3 алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд түрээсийн номын 7.2 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэх шилжүүлэг дансанд бүртгэснийг үндсэн үйл ажиллагааны орлого дансанд залруулав. Энэ нь УСНББОУС 01, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Хандиваар хүлээн авсан 0.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого аваагүй байна. Энэ нь УСНББОУС 01, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Нөхөн хангалтын орлогоос худалдаж авсан нэгж нь 0.9 сая төгрөгийн 16 ширхэг нийт 14.5 сая төгрөг, камер, самбар зэрэг үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгүүдийг бараа материалаар орлого авсныг үндсэн хөрөнгийн орлого авч бүртгэж залруулав. Энэ нь УСНББОУС 01, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 151.8 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 0.1 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 151.7 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

2.1 Төлбөрийн акт

1. Томилолтын зардлыг 0.1 сая төгрөгөөр илүү тооцож олгосон нь Төсвийн ерөнхий ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага шалгуур журмын 4 дүгээр зүйлийн 4.1.5-д “Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үндэслэн батлагдсан төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулж, төрийн өмч, төсвийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэх” гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Албан шаардлага

1. НДШ-ийн тайланд 2 ажилтны 1.6 сая төгрөгийн цалинг дутуу тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Төсвийн ерөнхий ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1-д “Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан балансын гаргалт, тооллого тооцоо, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг өөрийн болон харьяа байгууллагадаа байнга шалган зааварчилж байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Тендер зарлаагүй 150.1 сая төгрөгийн шууд худалдан авалт хийж зарцуулсан нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Захиалагч тендер шалгаруулалтыг энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэгт заасан аргаар зохион байгуулна”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Захиалагч энэ хуулийн 10.2-т заасан шууд худалдан авч болох төсөвт өртгөөс дээш тендер шалгаруулалтын зарлалыг тендер шалгаруулалтын баримт бичгийн хамт цахим системд нийтэлж, аж ахуй эрхлэгчийг танилцах боломжоор хангана” гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна,

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн үр дүнгийн тайланд түрээсийн номын орлогыг төвлөрүүлэх шилжүүлэг дансанд бүртгэсэн	1	7,232,8					1	7,232,8				
Хандиваар хүлээн авсан үндсэн хөрөнгийг орлого аваагүй байна.	1	275,0					1	275,0				
Нөхөн хангалтын орлогоос худалдаж авсан нэгж нь 0.9 сая төгрөгийн 16 ширхэг нийт 14.5 сая төгрөг, камер, самбар зэрэг үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгүүдийг бараа материалаар орлого авсан	1	14,384.0					1	14,384.0				
Дүн	3	27,461.1					3	27,461.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Томилолтын зардлыг 0.1 сая төгрөгөөр илүү тооцож олгосон	1	120.0	1	120.0								
НДШ-ийн тайланд 2 ажилтны 1.6 сая төгрөгийн цалинг дутуу тайлагнасан	1	1,562.6			1	1,562.6						
Тендер зарлаагүй 150.1 сая төгрөгийн шууд худалдан авалт хийж зарцуулсан байна	1	150,088.0			1	150,088.0						
Дүн	3	151,770.6	1	120.0	2	151,650.6						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 131.6 сая төгрөгийн 12 гүйлгээний мэдээллийг ил тод байршуулаагүй байна.	1	131,627.6			1	131,627.6		
Нийт дүн	1	131,627.6			1	131,627.6		



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

_____ оны _____ сарын _____ өдөр

Дугаар _____

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 171 мэдээллээс 11 мэдээллийг хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний 12 гүйлгээний 131,627,300.00 төгрөгийн мэдээллийг ил тод байршуулаагүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 1.2-т “Төрийн байгууллага, албан газар, төрийн өмчит хуулийн этгээд, үйлдвэрийн газар, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч (цаашид “байгууллага” гэх) нь шилэн дансны цахим хуудсанд Шилэн дансны тухай хууль болон энэ журамд заасны дагуу холбогдох мэдээллийг тавих үүрэгтэй” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11 дэх “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг мөрдөж мэдээллийг тогтмол тавих,

2125040522


биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан ажиллахыг Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ш.Батжав, нягтлан бодогч Б.Болортуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Э.НАНДИНЧИМЭГ

211744066
ХТҮ4437 9030891



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

_____ оны _____ сарын _____ өдөр

Дугаар _____

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд 2 ажилтны цалин хөлсийг 1,562,582.00 төгрөгөөр дутуу тайлагнасан.

Энэ нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/199 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам” -ын 2.2.6-д “Тайланд даатгуулагчийн төрөл, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээ, улсын кодыг үнэн зөв оруулсан байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11 дэх “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нийгмийн даатгалын шимтгэлийн тухайн сарын тайланд даатгуулагчийн цалин хөлсийг үнэн зөв оруулсан байх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Хууль эрх зүйн шийдвэрийг баримтлан ажиллахыг Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ш.Батжав, нягтлан бодогч Б.Болортуяа нарт даалгав.

2125040521

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Э.НАНДИНЧИМЭГ





ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 115/1962599
дсА - 2025/121/НА - СТА - ТМЗ

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг давсан 150,088,000.00 төгрөгийн бараа бүтээгдхүүнийг нээлттэй тендер шалгаруулах аргыг ашиглаагүй, бараа худалдан авах гэрээ байгуулаагүй худалдан авалт хийсэн.

Энэ нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх" зарчим, 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно" 39 дүгээр зүйлийн 39.3-т "Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана", 39.3.1-д "гэрээний үнэ", 39.3.2-т "гэрээний зүйл болон бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл", 48 дугаар зүйлийн 48.2.7-т "Худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх", 47.3-т "Бараа, ажил, үйлчилгээ хамтран худалдан авах төсвийн шууд захирагч тус тусын худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавина", Засгийн газрын 2024 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн 2 дугаар тогтоолын хавсралт "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар" -т заасныг тус тус зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9 дэх "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулах, Засгийн газрын 2024 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн 2 дугаар тогтоолын хавсралт "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан

2125040334

авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар” -ыг давсан үнийн дүнд тендер шалгаруулж гэрээ байгуулах, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Хууль эрх зүйн шийдвэрийг баримтлан ажиллахыг Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ш.Батжав, нягтлан бодогч Б.Болортуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Э.НАНДИНЧИМЭГ

